



ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ

Огноо: 2024.02.10

№ 23-24/02

Улаанбаатар хот

Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Үндэсний дээд лигийн Мэргэжлийн зөвлөл болон Ажлын хэсгийн өргөтгөсөн бүрэлдэхүүнд олгогдсон эрхийн дагуу Үндэсний дээд лигийн тэмцээнийг зохион байгуулах журмын 3 дугаар зүйлийн 3.8, 3.9, мөн журмын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.5 дахь хэсгүүд, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ёс зүйн дүрмийг тус тус үндэслэн дараах тогтоолыг үүгээр баталж байна.

ИЙНХҮҮ:

- A. Үндэсний дээд лигийн тэмцээний 2024 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн “ВСН Гарьд” – “Хасын Хүлгүүд” багуудын тоглолтын үеэр “ВСН Гарьд” багийн тоглогч Б.Болдбаатар нь Олон улсын сагсан бөмбөгийн холбооны дүрэм, Монголын Сагсан бөмбөгийн холбооны дүрэм болон Лигийн тэмцээн зохион байгуулах журмыг зөрчин талбайн шүүгчийн биед халдсан, хүчирхийллийн хэлбэр бүхий үйлдэл гаргасан байна.
- B. Энэхүү үйлдэл нь Үндэсний дээд лигийн тэмцээн түүний салшгүй нэг хэсэг талбайн шүүгчид, лигийн ажилчид болон үзэгчдийг илтэд үл хүндэтгэсэн ёс зүйгүй үйлдэл гаргасан байдлыг **ТЭМДЭГЛЭН**,

ТОГТООСОН НЬ:

1. “ВСН Гарьд” багийн тоглогч Бат-Эрдэнийн Болдбаатарыг Лиг зохион байгуулах журмын Хавсралтын Хариуцлага хэсгийн 3.3-т зааснаар 2024 оны 2 дугаар сарын 10-ний өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал Монголын Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд оролцуулахгүй байхаар тогтоосугай.

